

БҮХЭЛ ҮР ТАРИАНЫ NIR ХУРДАН, НАРИЙВЧЛАЛТАЙ, ХЯЛБАР



PerkinElmer Inframatic 9500
Бүхэл үрийн NIR

Зөвшөөрөгдсөн аргачлалууд:

- Австрали (NMI 15/1/5)
- Герман (PTB 11.26/13.01)
- АНУ (NTEP CC No. 13-112)
- Франц (LNE-27380)

Inframatic 9500

Салбарын жишиг технологийг төгөлдөржүүлэв

Inframatic 9500 нь үр тарианы худалдаачид, агуулахууд болон боловсруулах үйлдвэрийн хэрэгцээнд зориулан тусгайлан бүтээгдсэн төхөөрөмж юм. Энэ нь бүхэл үр тариа, тослог ургамал, буурцагт ургамал болон шошыг чийгшил, уураг, тос зэрэг үзүүлэлтүүдээр 1 минутаас бага хугацаанд шинжилнэ. Сүлжээнд бүрэн холбогддог, бат бөх, нарийн хэмжилттэй, ашиглахад хялбар төхөөрөмж юм.

Онцлогууд

IM 9500 нь салбарын стандарт NIR (хэт улаан туяаны) дамжуулалтын аргыг ашиглан дээжийг шинжилдэг ба нэмэлт онцлогуудын тусламжтайгаар хэмжилтийг илүү нарийвчлалтай, тогтвортой болгож, төхөөрөмжийн ажиллагааны хугацааг уртасгадаг. Монохроматорыг нэгэн цул металл блокноос хийсэн нь бүтцийг илүү бат бөх болгож, чичиргээ болон температурын өөрчлөлт хэмжилтэнд нөлөөлөх нөлөөг багасгадаг. Бүх төхөөрөмжүүдийг үйлдвэртээ АНУ-ын Үндэсний Стандартын Хүрээлэнгийн (NIST) долгионы уртын стандартаар тохируулсан тул хэд хэдэн төхөөрөмжийг нэгэн зэрэг ижил дээж дээр ижил үр дүн гаргах боломжтой. Төхөөрөмжийн ажиллагааг хянах, бүртгэлтэй өгөгдлийн сан бий болгох зориулалттай баталгаажсан стандарт шахмал хэлбэртэй шалгах дээжийг мөн ашиглах боломжтой. Эдгээр болон бусад олон онцлогуудын нийлбэр нь IM 9500-г бүхэл үр тариаг хурдан шинжлэхэд төгс төхөөрөмж болгодог.

Калибровк ба зөвшөөрөл

NIR технологи, өгөгдөл цуглуулалт болон калибровк хөгжүүлэлтийн чиглэлээр 40 гаруй жилийн туршлагатай бид дэлхийн хэмжээнд калибровк боловсруулах, хадгалах болон шинэчлэх бүрэн туршлагатай. Эдгээр Стандарт тохируулгууд нь төхөөрөмжийг худалдан авах үед тохиргоо хийгддэг. IM9500 нь дэлхийн олон улс орны зохицуулах байгууллагуудаас баталгаажсан ба үүнд Германы PTB, Францын LNE, Австралийн NMI, АНУ-ын NTEP зэрэг байгууллагууд багтдаг.

Онцлогууд ба давуу талууд

Хурдан	30 секундын шинжилгээ нь таныг ачааны машин ирж, ачиж буулгахтай зэрэгцүүлэн ажиллах боломжийг олгодог.
Нарийвчлал өндөр	Үр тариаг чанарт үндэслэн худалдаж авах, зарах боломжтой.
Ашиглахад хялбар	Дээжийг хийгээд мэдрэгчтэй дэлгэц дээр "шинжилгээ хийх" товчийг дарна.
Бат бөх	Ургац хураалтын ачаалалтай үед тасралтгүй ажиллахад тохирсон хамгийн оновчтой ажиллагааны хугацаатай.
Дэлхийн жишиг тохиргоо	Мянга мянган дээж дээр үндэслэсэн урьдчилан суулгасан тохиргоо нь төхөөрөмжийг бараг л шууд ашиглахад бэлэн болгодог.

Үзүүлэлт

Шинжилгээний бүтээгдэхүүн	Буудай, гурил, арвай, эрдэнэ шиш, шар буурцаг гэх мэт
Үзүүлэлтүүд	Чийг, уураг, тос
Шинжилгээний хугацаа	~25 секунд (нэмэлт модульгүй үед)
Дээжийн хэмжээ	400 мл (нэмэлт модультай үед 600 мл)
Дэд дээжийн тоо	16 хүртэл
Шинжилгээний арга	Хэрэглэгчийн тохируулгатай, дамжуулалтын зарчим
Долгионы урт	570-1100 нанометр
Хэмжээ (Өр х Урт х Өндөр)	485 x 390 x 370 мм (нэмэлт модультай үед 485 x 390 x 510 мм)
Жин	34 кг (нэмэлт модультай үед 40 кг)
Регресс анализ	PLS (Partial Least Squares), ANN (Artificial Neural Networks), HR (Honigs Regression)
Оролтууд	Ethernet, 4 USB порт
Дэлгэц	12 инч хэмжээтэй мэдрэгчтэй LCD
Хамгаалалт	Тоос, чийгэнд тэсвэртэй

Нэмэлт дагалдах хэрэгслүүд

Зориулалтын жингийн модуль	Гурилын модуль	Принтер	Лавлагаа дээж
Hectoliter Weight / Test Weight (анхны худалдан авалтын үеэр сонгох шаардлагатай)	Гурил болон хүүхдийн будааг 10 секундын дотор чийгшил, уураг, үнсний агууламжаар хэмжинэ (гурил, хүүхдийн будаа эсвэл хоёуланг нь сонгох боломжтой)	Шинжилгээний хариуг хэвлэнэ	Төхөөрөмжийн ажиллагааг тогтмол шалгах болон чанарын бүртгэл үүсгэхэд ашиглана.



NetPlus™ – NIR Grain Networking



Үр тариа худалдан авах, худалдахад тус бүрийн багажийг тохируулах тохиргоог бүрэн удирдах, шинжилгээний хариуг шууд хянах, сайжруулах нь чухал юм. Үүнийг Perten Instruments-ийн NetPlus Remote сүлжээний платформыг ашиглан хийж болно. NetPlus Remote-ээр дамжуулан сүлжээний удирдлага 24 цагийн турш нэвтрэх боломжтой.